

ТҮҮХ, НИЙГМИЙН УХААНЫ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН АГУУЛГА, АРГАЗҮЙ, ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН СУДАЛГААНААС

О.Пүрэв, доктор (Sc.D), профессор, Боловсролын Хүрээлэн
Д.Пунцагсүрэн, магистр, Боловсролын Хүрээлэн

Abstract: Present generation needs personal and social skills for 21st century such as learn independently, communication skills, team work and ethical use of ICT. As such, a purpose of the new concept of basic education history and social study curriculum was to develop and support students' learning. Application skills of history and social study knowledge were crucially embedded in the new curriculum. History and social study knowledge contain history, social evidence, perception, definition, law and natural order. Moreover, history and social study knowledge also contains skills such as inquiry historical and social inquiry, explaining and discussing skills. So, historical and social inquiry and problem solving skills were considered as one of the general skills of history and social study, and these skills were embedded in the curriculum content and methodology.

Our study found that scientific inquiry is a base of acquiring learning approach for history and social study. Also the study suggested that new learning approaches that are based on scientific inquiry and its use, characteristics and correlation are important to acquire learning approach for history and social study, and those approaches are open to teachers and educators to use in their learning activities. According to an empiric study on historical inquiry, 60 percent of the participants (students) responded that "It is a new approach which supports students' self-learning".

Assessment is an inseparable part of developing curriculum and implementing its learning objectives. History and social study curriculum was reformed to assess students' thinking and attitude towards historical and social process, and to discover their interest, desire and effort towards history and social study. Finally, this study recommended criterions for assessing students' development and attitude towards history and social study.

Түлхүүр үг: судлахуй, сурахуй, суралцахуй, сургалт, түүх, нийгмийн ухаан

Нэг. Түүх, нийгмийн ухааны боловсролын сургалтын агуулгын өөрчлөлт

XXI зууны сурагчийн хувийн болон нийгмийн хэрэгцээ нь бие даан тасралтгүй суралцах, бусадтай зөв харилцах, үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл харилцааны технологийг

хэрэглэх чадвартай болоход оршино. Тиймээс тухайн боловсролын сургалтын хөтөлбөр (Суурь боловсролын түүх, нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийн жишээгээр)-ийг шинэчилсэн үзэл баримтлал нь сурагчдын тасралтгүй суралцахуйг хөгжүүлэхэд чиглэсэн болно.

Зураг 1

Суралцахуйн хувьсгал- парадигмын өөрчлөлт (ойлголт, чадвар, хандлага—чадамж)


$\text{Суралцахуй} + \text{сургалт} = \text{судлахуй-сурахуй}$



Сурагчийн суралцахуйн үр дүн нь судлахуйд тулгуурласан сурахуй юм.

Зураг 2

Түүх, нийгмийн ухааны боловсрол ба хувь хүний хэрэгцээ, эдгээрийн хамаарал




Ийнхүү ТНУ-ы боловсролын агуулгын өнөөгийн өөрчлөлтийн үр дүнд суралцагчид суралцахуйн зорилтоор илэрхийлэгдэх агуулга буюу шинжлэн судлах арга барил, чадвар, хандлага эзэмших шинэлэг шийдэлтэй юм. Өөрөөр хэлбэл түүх, нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэхэд сурагчид түүх, нийгмийн шинжлэх ухаан (ТНШУ гэж товчлов)-ы мэдлэг болон ТНШУ-ны мэдлэгийг хэрэглэх чадвар эзэмших асуудалд тухайлан анхаарсан. Үүнд: ТНШУ-ны мэдлэгт түүх, нийгмийн баримт, ойлголт, тодорхойлолт, хууль, зүй тогтлыг хамааруулдаг. Харин ТНШУ-ны тухай мэдлэгт

түүх, нийгмийг шинжлэн судлах, тайлбарлах арга, чадварыг хамааруулна (Пүрэв, 2015, х.13). ТНШУ-ны мэдлэг, ойлголт, тодорхойлолт, хууль, зүй тогтлыг заан сургаж ирсэн уламжлал, туршлагатай ч түүх, нийгмийг шинжлэн судлах, тайлбарлах арга, чадварт сул анхаарсан нь дутагдал юм. Иймээс сурагчийн түүх, нийгмээр эзэмших ерөнхий чадвар суралцах арга барилын нэг нь түүх, нийгмийн үзэгдэл, үйл явц (Зураг. 3-ийг үзнэ үү.) буюу түүх, нийгмийн мэдээллийн эх сурвалж, тохиолдлыг (кейс) шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх арга гэж үзэж, энэ аргын талаар хөтөлбөрийн агуулга, аргазүйд тодорхой тусгасан юм.

Зураг 3

Түүх ба нийгмийн юмс, үзэгдэл, үйл явцын өөрчлөлт, холбоо



Хүснэгт 1

Түүх, нийгмийн ухааны боловсролын сургалтын цаг (2016 оны байдлаар)

Хичээл-судлагдахуун	Хичээлийн жилд тухайн ангид судлах цаг					Бүгд цаг
	Бага боловсролын түвшинд					
Хүн Орчин-I-III	I	II	III	IV	V	
Хүн ба нийгэм –IV-V	87	96	99	33	66	381

	Суурь боловсролын түвшинд				
	VI	VII	VIII	IX	
Нийгмийн ухаан	?	35	35	35	105
Түүх	35	70	70	70	245
Бүрэн дунд боловсролын түвшинд					
	X	XI	XII		
Нийгмийн ухаан (Заавал судлах)	70	70			140
Түүх (Заавал судлах)	35	35			70
Нийгмийн ухаан (Сонгон гүнгийрүүлж судлах)	1кр (43 цаг)	3кр (129 цаг)	5кр (215 цаг)		387
Түүх (Сонгон гүнгийрүүлж судлах)	1кр (43 цаг)	3кр (129 цаг)	5кр (215 цаг)		387
Бизнес судлал (Сонгон гүнгийрүүлж судлах)	1кр (43 цаг)	3кр (129 цаг)	5кр (215 цаг)		387
Нийт цаг					2102

Тайлбар:


1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөнд (2015, 2016, оны байдлаар) ТНУ-ны судлагдахуунууд ойролцоогоор 9.5 хувийг эзэлж байна
2. Нийгмийн ухааны хичээлийг 6 дугаар ангид судлуулах (одоогоор огт судлахгүй байгаа) шаардлагатай байна.

Хоёр. Аргазүйн шинэчлэлээс

Түүх, нийгмийн ухаанаар суралцагч сурах арга барилд суралцахуйн агуулга нь нэг талаас, түүх, нийгмийг шинжлэн судлах чадвар нөгөө талаас, түүх, нийгмийн үзэгдэл, үйл явцыг шинжлэн судлах арга барил (ШСАБ гэж товчлов.) болно. Өөрөөр хэлбэл, ШСАБ нь агуулга, үр дүн талаасаа чадвар, явцын талаасаа арга юм. Түүх, нийгмийг ШСАБ-ын алхамууд, тэдгээрийг эзэмшсэн суралцагч ямар чадвар, чадамжтай байхыг харуулав. (Зураг.4,5)

Зураг 4

Түүхийг шинжлэн судлах арга барил хандлага [Historical] (алхмуудар нь)




Түүхийн боловсрол эзэмшигчийн чадвар, чадамж




/Сингапур улсын жишээ, 2014 он/

Зураг 5

Нийгмийг шинжлэн судлах арга барил /хандлага [Social inquiry approach] (алхмуудар нь)



Нийгмийн ухааны боловсрол эзэмшигчийн чадвар, чадамж



ТНУ-ны сургалтад ШСАБ-ыг эзэмшиж, хэрэглэж буй байдалд судалгаа хийхэд багш суралцагчийн аль аль нь бэлтгэл дутмаг, хэлбэрдэх хандлага ажиглагдаж байна. Иймд ШСАБ-ын алхам бүрд судалгааны тоон болон чанарын аргаас зүй зохистой сонгон хэрэглэх нь зүйтэй. (Хүснэгт 2 -ыг үзнэ үү.)

Хүснэгт 2

Шинжлэн судлах аргын: алхмуудад тоон ба чанарын аргуудаас сонгох

Шинжлэн судлах арга барилын алхмууд	Тоон арга	Чанарын арга
Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх	о Асуулга	о Ажиглалт
Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах	о Стандарт сурвалжлага	о Ярилцлага (Фокус бүлгийн ярилцлага)
Мэдээлэл боловсруулах	о Социометр болон тест	о Сурвалжлага
Үр дүнг хэлэлцэх, шинэ санаа гаргах, танилцуулах	о Статистик баримт бичиг судлах	о Тохиолдол шинжлэх
	о Контент анализ	о Амьдралын түүх, соёл судлах
	о Нийгмийн туршилт г.м	о Намтар судлал г.м

ШСАБ-д судалгааны чанарын аргаас оновчтой сонгон хэрэглэхийн утга учир, ач холбогдлыг дор харуулав. Үүнд:

Чанарын судалгааны аргын философийн болон явцын шалтгаан	
Бодит үзэгдэл, херменевтик, хэл шинжлэл, утга зүй, экологи, феминизм, шүүмжлэлийн онол, нийгмийн конструктивизм, нийгмийн олон талт үзэгдэл, танин мэдэхүйн сэтгэл судлал (нөхцөлт болон нийгэм соёлын арга), шинэ марксизм, модернизмын дараах үе, шинжлэх ухааны философи, соёлын хүн судлал, бүтэц судлалын дараах үе, задлаг философи, бэлгэдлийн олон талт үзэгдэл, нийгмийн төлөөллийн онол г.м(Т.Отани, 2014, х.45)	Үйлдлийн шалтгаан: Тайлбарлах арга, онцгой гойд үзэгдлийн арга, байгалийн арга, бүтцийн арга, постпозитив буюу ард нь байрлах арга г.м Эдгээр нь бодит байх явдал, угсаатан судлал, угсаатны арга зүй, байршуулалтын онол, хүүрнэлийн арга, амьдралын өгүүлэл, амьдралын түүх, соёлын сэтгэл судлал, намтар судлал, соёл судлал зэрэг болно.
Өдөр тутмын амьдралд тулгуурлан: Туршилт, эрэлт хэрэгцээ, судалгаа шинжилгээ. Чанарын судлаач ямар нэг зүйлийг судлахдаа өөрийн өдөр бүрийн амьдралаас туршлагажиж, эрэлхийлж, судалгаа хийдгийг анхаарах хэрэгтэй.	

XXI зууны түүх, нийгмийн ухааны сургалтад дараах шинэлэг аргуудыг шүтэлцүүлэн хэрэглэх нь үр дүнтэй, өгөөжтэй гэдгийг бидний судалгааны үр дүн харуулж байна. Үүнд:

Түүх, нийгэм судлал, иргэний боловсролын сургалтын шинэлэг аргууд, тэдгээрийн хэрэглээний онцлог

(ЕБ-ын болон их, дээд сургуулийн түүх, нийгмийн ухааны сургалтад залгамж холбоотойгоор хэрэглэж болно)

Хүснэгт 3

№	Аргын төрөл	Түүх, нийгэм судлал, иргэний боловсрол	Аргын хэрэглээний онцлог
1	Элементарчлах арга	Түүх	Түүх, нийгмийн шинжлэх ухааны агуулгыг хялбаршуулж, гол санаа амин сүнснийг тодруулж, сурагчдад хялбар дөт, ойлгомжтой болгох арга, үйл
2	Олон өгүүлэмж, хүүрнэмжийн арга (нарратив)	Түүх	Түүх, нийгмийг танин мэдэх, утга зохиол, урлагийн нарратив бүтээлүүдийг олон өгүүлэмж, хүүрнэмжийн аргаар хэрэглэх
3	Зүйрлэл, адилтгалын арга (метафор)	Түүх	Түүхэн үзэгдэл, үйл явц болон ойлголтыг зүйрлэх, адилтгах аргаар сонирхолтой багшлах Жишээ нь, “Бөөр бөгсөнд Цэхэр цээжинд” гэсэн зүйрлэл Монголын нууц товчоо бүтээлийн 90-р зүйлд байдаг. Энэ нь “Хаан хааныхаа байр сууринд, харц харцынхаа байр сууринд” гэсэн мета санааг илэрхийлсэн зүйрлэл болохыг хэлэлцэх (бусад эх сурвалжуудаас ишлэл, зүйрлэл авч хэлэлцэх) г.м
4	Түүхийг тайлбарлах арга (интерпретаци)	Түүх	– Түүхэн үйл явдлыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тайлбарлах – Түүхэн үйл явдлын нөхцөл, шалтгаан, үр дагаварыг тодорхойлж, тайлбарлах – Түүхэн үйл явдал болон түүхэн хүмүүсийн үйл ажиллагаанд тухайн газар нутгийн нөхцөл онцлог (гадарга, уур амьсгал г.м) хэрхэн нөлөөлснийг үнэлэх, тайлбарлах – Өмнө үеийн түүхийг орчин үетэй холбож, харьцуулан шинжилж, тайлбарлах, гаргалгаа хийх
5	Ойлголтын зураглал хийх арга	Түүх, нийгэм судлал	Ойлголтуудыг оюун ухаанд хадгалагдах, шаардлагатай үед сэргээн хэрэглэх үүднээс гол шинж, төрөл, хамаарлаар нь зураглан харуулах
6	Хамтран (багаар) суралцах үйлийн арга	Түүх, нийгэм судлал, иргэний боловсрол	– Багт зохион байгуулагдах, ажил үүргээ хуваарилах, асуудлаа хэлэлцэх, шийдвэрлэх, тайлагнах, хамтын ажлын үр дүнгээ баг хоорондоо солилцох – Төсөлт ажлыг горим, үе шат (явц)-ын дагуу хамтаар хэрэгжүүлэх
7	Мэдээллийн технологийг ашиглах арга	Түүх, нийгэм судлал, иргэний боловсрол	Түүхийн баримт, өгөгдөхүүнийг мэдээллийн технологийг ашиглан олох, боловсруулах, хэрэглэх, солилцох, түгээх
8	Түүхэн сэтгэл судлалын арга	Түүх, нийгэм судлал, иргэний боловсрол	Түүхэн хүмүүсийн үг яриа, бичсэн, нийтлүүлсэн зүйлээр нь, тэдний үйлдэл, дүр төрх, үйл ажиллагааг сэргээн харуулж, хэлэлцэх, үнэлэлт өгөх (Пүрэв, 2007, х.23) Ж.нь: а) Түүхэн хүний намтар, дүр төрх б) Гол үйл ажиллагаа в) Гүйцэтгэсэн эерэг, сөрөг үүргийг энэ аргаар тодорхойлж болно.
9	Шугаман бус арга (синергетик арга)	Түүх, нийгэм судлал, иргэний боловсрол	Байгалийн ухааны боловсролын ололтыг ТНУ-ны боловсролд, ТНУ-ны боловсролын ололтыг байгалийн ухааны боловсролд шилжүүлэн, шүтэлцүүлэн хэрэглэх (Пүрэв, 2007, х.118)

Түүх, нийгэм, судлал, иргэний боловсролын сургалтын шинэлэг аргууд (шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, эх сурвалжтай ажиллах г.м)-ыг интеграцчилан хэрэглэх талаарх харьцуулалт (Пүрэв, 2015, х.21)

Хүснэгт 4


№	Аргын нэр	Аргын бүтэц	Ялгаатай тал	Нийтлэг тал	Тайлбар:
1	Шинжлэн судлах арга	-Асуулт, асуудал, таамаглал дэвшүүлэх -Эрж хайх, мэдээлэл цуглуулах -Мэдээллээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, нотлох, үнэлэх -Танилцуулах	-Нийгэм, түүхийн олон талт, өргөн хүрээтэй асуудлыг судлан шинжилдэг. -Дурдаж буй бүх аргын алхмуудыг өөртөө багтаадаг	Суралцагч төвтэй бүх аргын суурь үндэс болно	Энэ арга болон дараах арга бүр өөр, өөрийн өвөрмөц онцлогтой боловч үйл ажиллагааны алхмуудаараа ижил төстэй аж.
2	Мэдээлэл боловсруулах арга	-Мэдээлэл эрж хайх - Мэдээлэл олох, цуглуулах -Мэдээлэл боловсруулах (задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх) - Мэдээллээ солилцох, түгээх	Нэг төрлийн, тодорхой мэдээллийг боловсруулна. -Нийгэм, түүх бол бүхэлдээ мэдээллийн ертөнц гэж хэлж болно.	Энэ арга бүх аргад хэрэглэгддэг онцлогтой.	
3	Тохиолдол шинжлэх арга	-Тохиолдлыг эрж хайх, сонгох -Тохиолдлыг шинжлэх (задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, гаргалгаа хийх) -Тохиолдлын шинжилгээний үр дүнг танилцуулах	Нийгэм, түүхийн бодит үзэгдэл, үйл явцаас урган гарсан тохиолдол, мөн зохиосон тохиолдлууд ч байж болно.	Асуулт асуух, шинжлэх, хэлэлцэх, үр дүнг танилцуулах, тайлагнах зэрэг алхмуудаараа нийтлэг.	Энэ аргыг түүх, нийгмийн ухаанд хэрэглэхэд илүү тохиромжтой.
4	Асуудал шийдвэрлэх арга	-Асуудлыг олох, тодорхойлох, мөн чанарыг нь ойлгох, асуудал дахь өөрийн оролцоог ухаарах -Тухайн асуудлын таамаглал дэвшүүлэх (Телевиз үзэх нь сурагчийн оюун ухаан, эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлнэ г.м) -Тухайн асуудлыг шийдвэрлэх үйл явцыг сонгох, төлөвлөх -Асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа буюу таамаглалаа батлах, няцаах -Гарсан үр дүнг тодорхойлох, тайлагнах	Тодорхой нэг асуудлыг олж шийдвэрлэдэг онцлогтой.	Асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны алхмуудаараа нийтлэг.	Аль ч аргад асуудал шийдвэрлэх элемент байдаг.
5	Үйл (ажил)-ийн судалгааны арга	- Үйлийн асуудлыг тодруулах -Үйлийг төлөвлөх -Үйлдэл хийх (хэрэгжүүлэх) - Бодит ажил- үйлийн тэмдэглэл хөтлөх, эргэцүүлэх, үнэлэх -Үзэл баримтлалжуулах	-Нийгмийн бодит амьдрал, ажил-үйлийг судлана. -Үйлийн алхам бүрийг үзэл баримтжуулдаг	Нийгэм, түүхэн хүмүүсийн бодит амьдрал, ажил-үйлийг судалдагаараа нийтлэг шинжтэй.	

6	Төслийн арга	-Хэрэгцээг тодорхойлох -Шийдвэрлэх асуудлыг олох -Үйл ажиллагаагаа төлөвлөх -Хэрэгжүүлэх -Тайлагнах	-Хэрэгцээг бодитой тодорхойлдог -Тодорхой хугацаанд гүйцэтгэхийг шаардана.	Аль ч арга нь мэдээлэл цуглуулах, эрж хайх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх гэсэн үйлүүдээр ижил төстэй байна.	
---	--------------	---	---	---	--

ШСАБ-ын эзэмшилтийн эмпирик судалгаанаас (Пунцагсүрэн, 2015, х.56)

Лаборатори 5 сургуулийн, 8-р ангийн 200 сурагчийг хамруулсан асуулга судалгааг авсан болно. Үүнд:


Диаграмм 1



Асуулгын үр дүн

- ШСАБ-ыг байнга хэрэглэх нь сурагчдыг асуулт асуух, таамаглал дэвшүүлэхэд нь дорвитой нөлөө үзүүлээгүй гэж болно.
 - Асуулгын дүнгээс үзвэл сурагчдын асуулт тавих чадвар тааруу байгаа нь ажиглагдав.
 - Шинжлэн судлах үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах, эрж хайх чадвар сул байна. Яагаад гэсэн асуултад хариулах, юуг хэрхэн хийхээ сайн мэдэхгүй байдаг гэж сурагчдын 43 хувь нь хариулжээ.
 - Баримт, мэдээллийг задлан шинжилж чаддаг сурагчид тухайн аргын бусад алхмын гүйцэтгэлтэй харьцуулахад түвшин доогуур байгаа нь ажиглагдав.
 - Шинжлэн судлах арга барилыг эзэмших, хэрэглэх чадвар алхам бүрт тааруу байгаа тал ажиглагдаж байна.
- Түүхийн хичээлийн ажлын хуудсыг 100 сурагчаар гүйцэтгүүлж, шинжлэн судлах арга барил зэмших шалгуур боловсруулж, гүйцэтгэлийн үр дүнг гаргасан.

Диаграмм 2



Шинжлэн судлах арга барилыг хэрэглэх чадвар ажлын хуудасны гүйцэтгэлийн ерөнхий үр дүнгээс үзвэл, ихэнх сурагчид чаддаг, чаддаггүйн дунд байгаа нь илэрч байна.

- Ажлын хуудасны гүйцэтгэлийн шинжилгээнээс харвал, сурагчид дараах нийтлэг дутагдал гаргаж байна. Үүнд:

- Асуудал, таамаглал дэвшүүлж чаддаггүй
- Үйлийг төлөвлөж, мэдээлэл хайж, гол санааг гаргаж чаддаггүй
- Олон зүйлээс холбоо хамаарлыг гаргах чадвар сул
- Шинжилгээний үр дүнг илэрхийлж, танилцуулж чаддаггүй

Эдгээрээс үзвэл, шинжлэн судлах арга барилын дагуу боловсруулсан ажлын хуудасны гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тусгайлан боловсруулах, хэрэглүүлэх шаардлагатай байна.

Гурав. Үнэлгээний шинэчлэлээс

Сургалтын хөтөлбөр боловсруулах болон суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь үнэлгээ юм. Сурагчдын сурлагын ахиц амжилт буюу чадвар, ойлголт, хандлагыг явцын болон эцсийн үнэлгээгээр үнэлж

дүгнэнэ.

Сурагчийн сэтгэн бодох, түүх, нийгмийн үзэгдэл, үйл явцад үнэлэлт өгөх хандлага болон тэдний түүх, нийгмийн ухааны хичээлд хэр дур сонирхол, хүсэл эрмэлзлэл, хичээл зүтгэл, хандлагатай байгааг илрүүлэх, үнэлэхэд хөтөлбөр дэх үнэлгээний шинэчлэлийг чиглүүлсэн болно.

Жишээлбэл, түүхээр сурагчийн харилцаа, хандлагын төлөвшил (үйл явдлыг сонирхох сонирхол, идэвх зүтгэл, эрмэлзэл)-ийг (Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, 2015) илрүүлэх, үнэлэхэд цөм хөтөлбөрт дэх үнэлгээний зорилт, үнэлэх шалгуур үзүүлэлт, арга, хэрэгслийг тодруулж цэгцлэж тусгасан нь шинэлэг зүйл юм. Гэхдээ жишээ нь, түүхийн сургалтаар сурагчийн төлөвшил, хандлагыг үнэлэхэд дараах шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэх нь зүйтэй.


Үүнд: Сурагч түүхийн мэдлэг, ойлголт, үнэт зүйлийг хүлээн авахад хэр зэрэг бэлэн буй байдал

Сурагч түүхийн үзэгдэл, үйл явц болон түүхэн хүмүүсийн үйл ажиллагаанд хариу үйлдэл үзүүлж буй байдал

Сурагч түүхийн үзэгдэл, үйл явц, үнэт зүйлийг ач холбогдлоор нь эрэмбэлж, үнэлж, эрхэмлэж буй байдал

Сурагч түүхийн үнэт зүйл, үндэсний адилсалыг өөрийн итгэл үнэмшил болгож, түүнийхээ дагуу үйл, үйлдэл хийж буй байдал г.м

Диаграмм 3



Тайлбар: 1.Эргэцүүлэл, сэтгэлгээ, илэрхийлэл 2.Мэдээлэл боловсруулах, илэрхийлэх 3. Мэдлэг, ойлголтыг тайлбарлах, ашиглах 4. Сонирхол, идэвх зүтгэл, эрмэлзэл (СБСЦХ, 2015, х.22)

Хүснэгт 5 ТНУ-ны сургалтын хандлага (үнэт зүйл) төлөвшлийг

5.0 Үнэт зүйлсийн цогц үнэлэмж		4.0 Зохион байгуулалт		3.0 Үнэт зүйлс бий болох			2.0 Хариу үйлдэл үзүүлэх			1.0 Хүлээн авах		
5.2 Үнэлэмжтэй болох	5.1 Нэгтгэн дүгнэсэн сүлжээ бий болох	4.2 Үнэт зүйлсээ нотлох, батлах	4.1 Үнэт зүйлсийн үзэл баримтлалтай болох	3.3 Үнэт зүйлсээ нотлох, батлах	3.2 Үнэт зүйлсийг чухалчлах	3.1 Үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх, тохирох	2.3 Хариу үйлдэлдээ сэтгэл хангалуун байх	2.2 Хариу үйлдэл үзүүлэхэд бэлэн байх	2.1 Хариу үйлдэл үзүүлэхийг хүлээн зөвшөөрөх	1.3 Анхаарлаа сонгон хандуулах	1.2 Хүлээн авахад бэлэн байх	1.1 Ойлголттой болох

ДҮГНЭЛТ

1.ТНУ-ы боловсролын сургалтын агуулгад парадигмын өөрчлөлт гарсан бөгөөд энэ нь тухайн ШУ-ны “тунхагласан” мэдлэгүүдийг хэт шүтэх бус, харин эл боловсролын зорилго, бүтцийн үүднээс суралцагчиддаа зориулан дидактик реконструкц хийж бүтээсэн, өөрөөр хэлбэл, суралцахуйн зорилтоор тодорхойлогдсон, ТНУ-ны онцлогтой сурах арга барил, ойлголт, чадвар, хандлагын цогцыг шинэчилсэн агуулга гэж үзэх нь зохистой юм.

2. Суралцагч түүх, нийгмийн ухааныг судлах, эзэмших аргын үндсийн үндэс нь шинжлэн судлах арга барил, үүнд тулгуурласан түүхийн болон нийгмийн ухааны сургалтын шинэлэг аргууд, тэдгээрийн онцлог, хэрэглээний цогцлол, шүтэлцээг бидний судалгаа цэгцлэн тодруулсаныг

(Хүснэгт 3, 4) манай мэргэжлийн багш нар, суралцагчид практик амьдралд хэрэгжүүлэх нь нээлттэй, боломжтой хэмээн дүгнэж байна.

3. Суралцагч түүх, нийгмийн үзэгдэл, үйл явцыг шинжлэн судлах арга бариныг эзэмших, хэрэглэх үйл ажиллагаанд гарч байгаа зарим хэлбэрдлэгийг гэтлэх арга замын нэг бол энэ аргын алхам бүрд (Асуудал, таамаглал дэвшүүлэх, Төлөвлөх, мэдээлэл цуглуулах, Боловсруулах, үнэлэх, Танилцуулах) судалгааны тоон болон чанарын аргуудаас (Хүснэгт 2) оновчтой сонгон хэрэглэх чадварыг тэдэнд зөвлөн эзэмшүүлэх (эзэмших) шаардлагатай байна. Үүний сацуу эл чадвар хийгээд аргыг эзэмших, хэрэглэх цагийг зөвхөн хичээлийн 60, 80 минутад бус, дийлэнх тохиолдолд үргэлжлүүлэн хичээлээс гадуурх

болон 7, 14, 21, сар, сараас дээш хугацаагаар хэрэгжүүлэх нь бодитой, өгөөжтэй гэж үзэж байна.

4. Түүхийн сургалт дахь шинжлэн судлах арга барилын эмпирик судалгааны дүнгээс үзвэл, уг аргыг шинэлэг арга хэмээн сурагчдын 60 хувь нь үзэж, бие даан суралцах боломжийг олгож байна хэмээн дүгнэсэн байна. Багш нар түүхийн сургалтад шинжлэн судлах арга барилыг хэрэглэх нь сурагчдын бүтээлч үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх сайн талтай ч эл аргыг байнга хэрэглэх бололцоо хязгаарлагдмал бөгөөд хичээлийн сэдэв, онцлог, бодит боломж, орчин нөхцөл зэрэг хүчин зүйлсийг харгалзан хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн байна.

5. Суурь боловсролын ТНУ-ы сургалтын цөм хөтөлбөр нь нэлээд шинэлэг шийдэлтэй хэмээн үзэж болох ба энэ шийдлүүдийг бүрэн дунд боловсролын ТНУ-ы цөм хөтөлбөрт залгамжлан хэрэглэх шаардлагатай, ялангуяа хөтөлбөрийн болон үнэлгээний шинэчлэлийг (үнэлгээний зорилт, арга, хэрэгслийг хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан тодорхойлсон) хамтад нь хийсэн нь шинэлэг, практикийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

6. Судалгаанаас харвал, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын шинэчилсэн төлөвлөгөөнд ТНУ-ны хичээл ойролцоогоор 9.5 хувь эзэлж байгааг олон улсын жишгийг (12 хувиас доошгүй байдаг) харгалзан нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна. Тухайлбал, ЕБС-ийн 6-р ангид НУ-ыг заавал судлах, мөн бага боловсролын “Хүн ба орчин” хичээл дэх нийгмийн ухааны агуулгыг доктор Ц.Дэлгэрсайхан нарын (2013) судалгааг үндэслэн зохистой харьцаагаар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2015). Суурь боловсролын цөм хөтөлбөр: Түүх, нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт. (2015). Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага (Пүрэв, Суурь боловсролын нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлалаас)
- Пүрэв, О. (2001). Түүх, нийгмийн ухааны боловсрол. Улаанбаатар
- Пүрэв, О. (2007). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. Улаанбаатар
- Пүрэв, О. (2003). XXI зууны Монголын түүх, нийгмийн ухааны боловсролын онол ба методологи (Шинжлэх ухааны докторын диссертаци). Улаанбаатар
- Пунцагсүрэн, Д. (2015). Сурагчид шинжлэн судлах арга барил эзэмших арга замыг судалсан нь. *Магистрын дипломын ажил*. Улаанбаатар
- James A, Bank. (1990). Teaching strategies for the social studies
- О.В. Горбачева., С.Б. Каун и другие. (1996). Методология истории Минск Вэб хаяг:
- Canad Oslo curriculum. (2010). iris.info.yorku.ca/files/2007/04/Annual-Report-2010-2011-FINAL.pdf
- Bell., Collaborative inquiry learning International journal of science education 3(1), 349-377 view.wikispaces.com/file/view/collab+inquiry+learning.pdf